



MOTCAPITAL

Нууцлалын Бодлого

Улаанбаатар хот

НУУЦЛАЛЫН БОДЛОГО

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү нууцлалын бодлого /цаашид **“Нууцлалын бодлого”** гэх/-ийн зорилт нь “MOT Капитал” ХХК /цаашид **“Компани”** гэх/-ийн платформ <https://www.motcapital.com> /цаашид **“Платформ”** гэх/-д нэвтрэх, бүртгүүлэх, хувийн мэдээллээ баталгаажуулах, арилжааны жинхэнэ данс болон демо данс нээх, өөрийн дансны гүйлгээг удирдах зэрэг /цаашид **“Үйлчилгээ”** гэх/-г үзүүлэхэд шаардлагатай хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулах, хадгалахтай холбоотой талуудын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү нууцлалын бодлогод зөвхөн **“MOT Капитал”** ХХК /цаашид **“Үйлчилгээ үзүүлэгч”** гэх/ нь өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд тухайн өөрчлөлтийг үйлчилгээ үзүүлэгч нь албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдэгдэнэ.
- 1.3 Энэхүү нууцлалын бодлого нь Монгол улсын Үндсэн хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

ХОЁР. ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

- 2.1 Хэрэглэгч энэхүү нууцлалын бодлогыг хүлээн зөвшөөрч, дараах мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулах, хадгалах зөвшөөрлийг олгосон болно. Үүнд:
 - 2.1.1 Бүртгүүлэх
 - Овог, нэр, хүйс, иргэншил, утасны дугаар, и-мэйл хаяг
 - 2.1.2 Хувийн мэдээлэл баталгаажуулах
 - Иргэний үнэмлэхийн лавлагаа
 - Оршин суугаа хаягийн тодорхойлолт
 - Овог, нэр, төрсөн өдөр, оршин суугаа хаяг
 - Ажил эрхлэлтийн мэдээлэл
 - Орлогын эх үүсвэр, санхүүгийн мэдээлэл
 - Арилжааны туршлага
 - Бусад шаардлагатай мэдээлэл
- 2.2 Хэрэглэгч <https://www.motcapital.com>-ийн бүртгэлд нэвтрэх нэр, нууц үг, и-мэйл хаяг, MetaTrader 5 болон cTrader арилжааны платформд нэвтрэх боломжтой арилжааны дансны нэвтрэх нэр, нууц үг зэрэг хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, бусдад задруулах, илгээх, сэжигтэй линк, веб сайтад бүртгүүлэх, нэвтрэх зэрэг бусад бүх төрлийн аюулгүй байдалтай холбоотой үйлдлийг хийхгүй байх үүрэгтэй.
- 2.3 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчтэй албан бус хаягаар харилцах, дансны бүртгэл, нэвтрэх нэр, нууц үг зэрэг бусад хувийн мэдээллийг шаардахгүй тул мэдээллийн аюулгүй байдлаа сайтар хангаж, цахим залилангийн шинжтэй хууран мэхлэх үйлдлээс урьдчилан сэргийлнэ үү.

ГУРАВ. ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ, АШИГЛАХ

- 3.1 Хэрэглэгч энэхүү нууцлалын бодлогыг хүлээн зөвшөөрч, дараах мэдээллийг боловсруулах, ашиглах зөвшөөрлийг олгосон болно. Үүнд:
 - 3.1.1 Хэрэглэгчийн мэдээллийн үнэн зөвийг шалгаж, хэрэглэгчийг таньж мэдэх баталгаажуулах;
 - 3.1.2 Хэрэглэгчийн ямар байршил, төхөөрөмжөөс платформд хандалт хийж буйг тодорхойлох, бүртгэл үүсгэх;
 - 3.1.3 Хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргахтай холбоотойгоор судалгаа шинжилгээ, статистикийн мэдээлэл бэлтгэх зорилгоор ашиглах;

- 3.1.4 Үйлчилгээ үзүүлэгчийн санал болгож буй үйлчилгээ, аливаа сурталчилгаа, хөнгөлөлт, урамшуулалтай холбоотой мэдээлэл, нэмэлт өөрчлөлт болон шаардлагатай бусад мэдээллийг хэрэглэгчид хүргэх;
- 3.1.5 Хэрэглэгчийн арилжааны түүхийг баталгаажуулах, шалгах;
- 3.1.6 Хэрэглэгчийн хувийн мэдээлэл задрах, алдагдахаас урьдчилан сэргийлэх боломжтой бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 3.1.7 Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сэжигтэй гүйлгээний талаар эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх;
- 3.1.8 Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу маргаантай, эсхүл цахим залиллангийн шинжтэй гүйлгээг илрүүлэх, засварлах, таслан зогсоох, шийдвэрлэх арга хэмжээ авах.

ДӨРӨВ. ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ

- 4.1 Үйлчилгээ үзүүлэгч нь хэрэглэгчийн мэдээллийг энэхүү нууцлалын бодлого болон дараах нөхцөлд зааснаас бусад тохиолдолд хэрэглэгчийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахгүй болно. Үүнд:
 - 4.1.1. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, шаардлагын дагуу тус байгууллагад хууль тогтоомжид заасан үндэслэл, хэлбэр хэмжээний хүрээнд дамжуулна.

ТАВ. ХЭРЭГЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ ХАДГАЛАХ, ХАМГААЛАХ

- 5.1 Хэрэглэгч өөрийн хувийн мэдээллийг цуглуулах зөвшөөрлөө цуцалсан бол үйлчилгээ үзүүлэгч нь зөвшөөрөл цуцлагдахаас өмнө цуглуулсан, боловсруулсан, ашигласан мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зөвшөөрөл цуцлагдсан өдрөөс хойш хамгийн багадаа 10 жилийн хугацаанд хадгална.
- 5.2 Хэрэглэгч өөрийн бүртгэлд аливаа гуравдагч этгээд зөвшөөрөлгүйгээр нэвтрэх, таны нууц үгийг ашиглаж байгаа үйлдлийг олж илрүүлвэл нэн даруй манай хэрэглэгчийн үйлчилгээний албаны 7222-2200 дугаарт холбогдох эсхүл support@motcapital.com цахим шуудангийн хаягаар яаралтай мэдэгдэх үүрэгтэй.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1 Энэхүү нууцлалын бодлогод заасан мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, дамжуулахтай холбоотой зөвшөөрөл нь нууцлалын бодлого хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд, эсхүл хэрэглэгч өөрийн зөвшөөрлийг цуцлах хүртэл хүчин төгөлдөр байна.
- 6.2 Үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрсдэлийг хариуцахгүй болно. Үүнд:
 - 6.2.1 Үйлчилгээ үзүүлэгчийн систем нь цахим халдлагад өртөх эсхүл ирээдүйд учирч болзошгүй, үйлчилгээ үзүүлэгчийн хянах боломжгүй бусад бүх эрсдэлийг;
 - 6.2.2 Хэрэглэгч өөрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаагүйгээс үүдэн гуравдагч этгээд зөвшөөрөлгүйгээр хэрэглэгчийн дансыг ашиглах эсхүл залруулах боломжгүй, залиллан мэхлэх шинжтэй гүйлгээ, цахим халдлагыг;

ДОЛОО.ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1 Гэнэтийн давагдашгүй нөхцөл байдлын улмаас буюу үер, газар хөдлөлт, цаг агаарын онцгой нөхцөл байдал, байгалийн гэнэтийн хүчин зүйлс, гал түймэр, дайн, бослого, үймээн самуун, халдварт өвчин, аливаа бүх төрлийн осол, засгийн газрын үйл ажиллагаа, шийдвэр, хориг, харилцаа холбоо болон цахилгаан тасрах, тоног төхөөрөмж болон программ хангамж эвдрэх, хакер халдлага зэрэг үйлчилгээ үзүүлэгч хянах боломжгүй нөхцөлд <https://www.motcapital.com>-ийн үйл ажиллагаа тасалдах, түр зогсох, засвар үйлчилгээ хийх тохиолдолд үйл ажиллагааг хэвийн горимд шилжих хүртэлх хугацаанд учирсан хохирлыг үйлчилгээ үзүүлэгч хариуцахгүй болно.

НАЙМ.БУСАД ЗҮЙЛ

- 8.1 Энэхүү нууцлалын бодлоготой холбоотой талуудын хооронд үүсч болзошгүй бүх санал зөрөлдөөн, аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжоор шийдвэрлэнэ.
- 8.2 Энэхүү нууцлалын бодлогоор зохицуулаагүй аливаа харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

ooOoo



www.motcapital.com
support@motcapital.com